



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 04. 29 № 13

Г Асуулга тавих тухай

Хөдөөгийн иргэд, сонгогчидтой хийсэн уулзалтын үеэр бэлчээрийн талхагдал, хөрсний доройтол, уур амьсгалын хуурайшилтаас болж цөлжих үйл явц хурдассан, үлийн цагаан оготны тоо хэт олширсон зэргээс бэлчээр доройтох, зарим хэсэг нь түймэрт өртөн мал ахуй эрхлэн амьдрахад хэцүү болж байгаа тухай ярьж, арга хэмжээ авч өгөх хүсэлт ихээр тавьж байна.

Энэ байдлыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Таньд тавьж байна. Үүнд:


1. Засгийн газраас бэлчээрийн ургамлын төрөл зүйлийг олшруулах, хөрсний эвдрэл, уур амьсгалын хуурайшилт, цөлжилтийг багасгах, үлийн цагаан оготны тархалтыг зогсоох чиглэлээр хийж буй ажил, үр дүн, авах арга хэмжээний талаар;
2. Мал хаваржилт, үүлэнд зориудаар нөлөөлж бороо, хур оруулах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр хийж буй ажил, үр дүн, авах арга хэмжээний талаар;
3. Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх нисдэг тэрэг, техник, багаж хэрэгсэлийн хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийг гол түймэртэй тэмцэх ажилд дадлагажуулах чиглэлээр хийж буй ажил, үр дүн, авах арга хэмжээний талаар.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Б.БАТ-ЭРДЭНЭ



0000000056